



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
АНХДУГААР ХУРЛЫН МАТЕРИАЛ

MICROSOFT OFFICE USER

Улаанбаатар хот  
2018.01.08

## Агуулга

ХУРЛЫН ЗАР .....	2
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХДУГААР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ .....	2
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХДУГААР ХУРЛЫН ДЭГ .....	3
ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ БАРИМТ БИЧИГ .....	4
АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА .....	5
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА.....	6
ТУЗ –ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД: .....	7
ТУЗ –ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД: .....	16
ШИНЭЧИЛСЭН ДҮРМИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....	21
ТОГТООЛЫН ТӨСӨЛ.....	42
САНАЛЫН ХУУДАС.....	47
САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ.....	48

## ХУРЛЫН ЗАР

“Айтүүлс” ХК –ийн хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурал 2018 оны 01 дүгээр сарын 08 – ны өдрийн 15:00 цагт Сүхбаатар дүүргийн 8 –хороо, Бага тойруу-49 Мэдээлэл, технологийн үндэсний паркийн хурлын танхимд болох тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын зарыг олон нийтэд мэдээлэх мэдээллийн хэрэгслүүд:

- Монголын хөрөнгийн биржийн веб сайт;
- “Өнөөдөр сонин” –ы 2017 оны 11 сарын 28 –ны дугаар, 2017 оны 12 сарын 13 –ны дугаар;
- Компанийн өөрийн веб сайт болон нийгмийн сүлжээ.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2017 оны 12 сарын 14 – ны өдрөөр тогтоосон болно.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХДУГААР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

1. Анхдагч зах зээлийн арилжааны тухай танилцуулах;
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. Компанийн дүрмийг шинэчлэн батлах.

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс энэхүү материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер диллерийн компанидаа 2018 оны 01 сарын 05 –ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХДУГААР ХУРЛЫН ДЭГ

№	Хөтөлбөр	Үргэлжлэх хугацаа
1	Хурлын ирц бүртгэх /Зохион байгуулах комисс/	20 минут
2	Хурлын ирцийг мэдээлэх /тооллогын комисс/	5 минут
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах /Хурлын дарга/ - Ерөнхий танилцуулга	20 минут
4	Айтгүүлс ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааны тухай танилцуулах;	5 минут
5	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах;	10 минут
6	Компанийн шинэчилсэн дүрмийн төслийг танилцуулах;	10 минут
7	Асуулт, хариулт	30 минут
8	Санал хураалт	10 минут
9	Хурлын завсарлага, санал тоолох	20 минут
10	Санал хураалтын дүнг танилцуулах /тооллогын комисс/	5 минут
11	Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах /Хурлын дарга/	5 минут
12	Хурлыг хаах /Хурлын дарга/	5 минут

Хурлын үргэлжлэх хугацаа: 3 цаг

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

## ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ БАРИМТ БИЧИГ



### АЙ СИ ТИ ГРУПП ХХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 11/1

Улаанбаатар хот

Айтүүлс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг  
хуралдуулах тухай

“Ай Си Ти Групп” ХХК-ийн 2017 оны 11 сарын 23-ны өдрийн 11/1 тоот хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Айтүүлс ХК-ийн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж, компанийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулсугай.
2. Ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцсүгэй. Үүнд:
  - 2.1. Анхдагч зах зээлийн арилжааны тухай танилцууцах;
  - 2.2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
  - 2.3. Компанийн дүрмийг шинэчлэн батлах;
3. Хурлын тов: 2018 оны 1 сарын 8 өдөр, 15:00 цагт  
Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу-49.  
Мэдээллийн технологийн үндэсний паркийн хурлын танхимд
4. Бүртгэлийн өдөр: 2017 оны 12 сарын 13 өдөр
5. Хурлын дарга: А.Баттамир
6. Тооллогын комиссын гишүүд: Д.Бямбасүрэн, Н.Төгөлдөр
7. Хурлыг хууль журмын дагуу зарлах болон зохион байгуулах ажлыг Айтүүлс ХК-ийн Гүйцэтгэх захирал И.Алтантулгад даалгасугай.
8. “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын хавсралтаар батлагдсан мэдэгдлийг 2017 оны 11 сарын 24-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж-д хүргүүлэх, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2017 оны 11 сарын 28-ны өдөр тутмын сонинд мэдээлэх, мөн уг зарыг 2017 оны 12 сарын 13-ны өдөр анх мэдээллэсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхээр тогтсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-ээр баталсугай.
10. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2018 оны 1 сарын 5-ны өдрөөр тогтоосугай

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:



/Ц.ГАНБОЛД/ Ворлд Френдс ХХК –ийг төлөөлж

/А.БАТТАМИР/

## АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

“Айтүүлс” ХК нь 13,387,980 ширхэг хувьцааг нэгжийн үнэ 100 төгрөгөөр санал болгосон.

“Айтүүлс” ХК –ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжааны системээр дамжуулан 2017.11.01-2017.11.10 өдрүүдэд авсан бөгөөд 1,075 хөрөнгө оруулагчийн 39,789,996 ширхэг хувьцаа худалдан авах захиалга ирсэн байна. Үүнээс худалдах авахаар өгсөн захиалгандаа мөнгөний үлдэгдэл нь хүрэлцэхүйц 954 хөрөнгө оруулагчийн 37,978,448 ширхэг хувьцаа авах захиалга нь хүчин төгөлдөрт тооцогдсон болно. Энэ нь компанийн нийт татах 1,338,798,000 төгрөгийн үнийн дүнгээс 2.84 дахин давсан худалдан авах захиалга байсан байна.

### “Айтүүлс” ХК –ийн анхдагч зах зээлийн захиалгын хуваарилалт

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер компанийн зүгээс үнэт цаасны худалдан авах захиалга нийт худалдах тоо ширхгээс давсан тохиолдолд доорх нөхцлүүдээр хуваарилахаар шийдвэрлэсэн.

1. 50.0 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалгыг бүрэн биелүүж, 50.0 сая төгрөгөөс дээш давсан дүнг хувь тэнцүүлэн хуваарилна;
2. Хэрэв 50.0 сая төгрөг хүртэлх захиалгын дүн нь нийт татах үнийн дүнгээс давсан тохиолдолд 1.0 сая төгрөг хүртэлх үнийн дүнг бүрэн биелүүж, 1.0 сая төгрөгөөс дээш дүнг хувь тэнцүүлэн хуваарилна.

Дээрх анхдагч зах зээлийн хуваарилалтын зарчмын дагуу хүчин төгөлдөрт тооцогдсон нийт захиалга бүрийн 50 сая хүртэлх үнийн дүн нь нийт татах 1,338,798,000 төгрөгийн үнийн дүнгээс давсан учраас хөрөнгө оруулагч бүрийн 1.0 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалга бүрэн биелэж түүнээс давсан захиалга бүр 23.3 хувиар хувьчлагдан биелсэн байна.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд:

1. Зэсэмийн МЯГМАРСҮРЭН;
2. Даваасүрэнгийн ДАВАА;
3. Бороохойн ЭНХБОЛД;
4. Лхагвын ТЭМҮҮЛЭН;
5. Энхтуяагийн НАРАНМӨНХ;
6. Пүрэв-Одсэрийн ЭНХТУЛГА;
7. Амарсайханы ДӨЛГӨӨН;
8. Мөнхтөрийн МӨНХБАЯСГАЛАН;
9. Пүрэвсүрэнгийн АНХБОЛД.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд:

1. Адилбишийн БАТТАМИР;
2. Идэрмөнхийн АЛТАНТУЛГА;
3. Гантулгын ХАТАНБОЛД;
4. Баярмагнайн ЭРДЭНЭЖАРГАЛ;
5. Нанжидын УЛААНХҮҮ.

**ТУЗ –ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД:**

**1 нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Зэсэмийн МЯГМАРСҮРЭН**
- Хүйс: Эмэгтэй
- Төрсөн он: 1967
- Төрсөн газар: Төв аймаг, Сэргэлэн сум



*Боловсролын талаарх мэдээлэл:*

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Санхүү эдийн засгийн дээд сургууль	Улаанбаатар	2000	2003	Бизнесийн удирдлага, зах зээл судлаач эдийн засагч
2	ММНБИ	Улаанбаатар	2000	2003	Аудитор
3	ММНБИ	Улаанбаатар	1995	2003	Мэргэшсэн нягтлан бодогч
4	Санхүү эдийн засгийн техникум	Улаанбаатар	1985	1987	Нягтлан бодогч, эдийн засагч
5	Ерөнхий боловсролын сургууль	Төв аймаг	1975	1985	


*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Бодьгусгал-Аудит ХХК	Захирал	2011 оноос хойш
2	Нийслэл-Аудит ХХК	Ахлах аудитор	2005-2011
3	ЭсЭм-Аудит ХХК	Төв аймгийн салбарын захирал	2003-2005
4	Эрдэнэ УУГ	Ерөнхий ня-бо	1989-2003
5	Төв аймгийн Сэргэлэн сум ХБА	Нягтлан бодогч	1987-1989



**II нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Даваасүрэнгийн ДАВАА**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1981
- Төрсөн газар: Говь-Алтай аймаг



№	Таны юу болох	Гэр бүлийн гишүүдийн эцэг /эх/ -ийн болон өөрийн нэр	Төрсөн огноо	Төрсөн газар	Одоогийн ажил эрхлэлт	Утасны дугаар
1	Эхнэр	Энхтайваны Өнөржаргал	1983	Улаанбаатар	Хувиараа	
2	Хүү	Даваагийн Төгс-эрдэм	2003	Улаанбаатар	Сурагч	
3	Хүү	Даваагийн Төгсбилэг	2006	Улаанбаатар	Сурагч	
7	Хүү	Даваагийн Тэнүүн	2015	Улаанбаатар	Гэртээ	

**Боловсролын талаарх мэдээлэл:**


№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС-КТМС	Улаанбаатар	1998	2002	Програм, техник хангамж
2	Дархан-Уул аймгийн 15-сургууль	Улаанбаатар	1989	1998	Бүрэн дунд боловсрол

**Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:**

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	ККТГ ХХК	Бизнес хариуцсан захирал	2016-2017
2	Дайей-Пробис Монгол ХХК	Менежер	2014-2016
3	Цагдаагийн ерөнхий газрын	Мэдээлэл технологийн төвийн тасгийн дарга, хэлтсийн дарга, төвийн дарга	2008-2014
4	Эрүүгийн цагдаагийн ерөнхий газар	Төлөөлөгч, ахлах төлөөлөгч	2001-2008

**III нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Бороохойн ЭНХБОЛД**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1985
- Төрсөн газар: Улаанбаатар хот



*Боловсролын талаарх мэдээлэл:*

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Массачусетсийн их сургууль	АНУ	2013	2014	МВА Санхүүгийн магистр
2	Кван-уун их сургууль	БНСУ	2004	2009	Бизнесийн бакалавр
3	МУИС лицей	Монгол	1997	2002	Ерөнхий боловсрол

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Худалдаа хөгжлийн банк	Кастодиан үйлчилгээний хэлтэс, захирлын үүрэг гүйцэтгэгч	2014 оноос хойш
2	Массачусетсийн их сургууль, Дартмот, АНУ санхүүгийн тэнхим	Багшийн туслах ажилтан	2014.09-2014.12
3	Худалдаа хөгжлийн банк	Данс хариуцсан ажилтан	2010-2013
4	Есөн-Эрдэнэ хоолны газар /БНСУ/	Бизнес эрхлэгч	2008-2009

**IV нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Лхагвын ТЭМҮҮЛЭН**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1982
- Төрсөн газар: Улаанбаатар хот



*Боловсролын талаарх мэдээлэл:*

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огно	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Канберра хотын их сургууль	Канберра хот Австрали улс	2011	2012	Эрх зүйн ухааны магистр
2	Төв Күийнзлэндийн Их сургууль	Сидней хот Австрали улс	2003	2006	Бизнесийн удирдлагын бакалавр
3	Нийслэлийн 10 жилийн 1-р дунд сургууль	УБ, Монгол улс	1997	1999	Бүрэн дунд боловсрол

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Тэлмэнхас ББСБ	Хувьцаа эзэмшигч	7 жил
2	ХААН Банк	Ахлах хуулийн зөвлөх	5 жил
3	Монголын Хөрөнгийн бирж	Гадаад харилцааны мэргэжилтэн	2 жил
4	Asia Pacific Investment Partners	Арилжааны брокер	1 жил

**V нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Энхтуяагын НАРАНМӨНХ**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1987
- Төрсөн газар: Улаанбаатар хот



*Боловсролын талаарх мэдээлэл:*

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС-КТМС	Улаанбаатар	2003	2007	Программ хангамжийн инженер бакалавр
2	ШУТИС –Математикийн лицей	Улаанбаатар	2001	2003	Бүрэн дунд

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Greensoft	Head of sales & Marketing	2016 оноос хойш
2	Новасофт ХХК	Head of sales & Marketing	2013-2016
3	Гацуурт трейд	Co founder & Dealer	2011-2013
4	Asia pacific investment partners	Webmaster	

**VI нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Пүрэв-Одсэрийн ЭНХТУЛГА**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1988
- Төрсөн газар: Улаанбаатар хот



*Боловсролын талаарх мэдээлэл:*

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ХҮДС	Улаанбаатар	2006	2010	Санхүүгийн удирдлага, НББ бакалавр
2	1-р дунд сургууль	Улаанбаатар	1996	2006	Бүрэн дунд

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Хаан банк	Аудитор	2010 оноос хойш

**VII нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Амарсайханы ДӨЛГӨӨН**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1982
- Төрсөн газар: Дархан-Уул аймаг



*Боловсролын талаарх мэдээлэл:*

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС-КТМС	Улаанбаатар	1999	2006	Программ хангамж бакалавр
2	Дархан 7-р сургууль	Дархан	1989	1999	Бүрэн дунд

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Мөнх Хакер ХХК	IT инженер	2017.08 оноос хойш
2	Дархан-Уул аймгийн УЦУОШГазар	Систем сүлжээний захирагч	2009-2017
3	Дархан-Уул аймгийн ЗДТГазар	16-р багийг хариуцсан IT мэргэжилтэн	2006-2007
4	Монпрог ХХК	Веб дизайнер	2001-2006

**VIII нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Мөнхтөрийн МӨНХБАЯСГАЛАН**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1984
- Төрсөн газар: Сэлэнгэ аймаг, Сайхан сум



*Боловсролын талаарх мэдээлэл:*

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Удирдлагын академи	Улаанбаатар	2014	2015	Нийтийн удирдлага
2	МУБИС	Улаанбаатар	2005	2009	Урлаг судлаач
3	Хөтөл ЕББДС	Хөтөл	1992	2002	Бүрэн дунд

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Офишл ХХК	Менежер	2017.11 хойш
2	Хөтөл соёлын ордон	Орон нутаг сурталчилах танхимын ажилтан	2012-2017
3	Монголын уран зургийн галерей	Бүртгэл мэдээллийн санч	2010-2012

**IX нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Пүрэвсүрэнгийн АНХБОЛД**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1988
- Төрсөн газар: Дархан-Уул аймаг



*Боловсролын талаарх мэдээлэл:*

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Дархан дээд сургууль	Дархан	2005	2009	Нягтлан бодогч, эдийн засагч бакалавр
2	Оюуны ирээдүй цогцолбор	Дархан	1995	2005	Бүрэн дунд

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Чингис хаан банк	Харилцааны менежер	2016 оноос хойш
2	Хаан банк	Харилцааны менежер	2009-2016



**ТУЗ –ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД:**

**Г нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Адилбишийн БАТТАМИР**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1982
- Төрсөн газар: Улаанбаатар хот



*Боловсролын талаарх мэдээлэл:*

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС-КТМС	Улаанбаатар	1998	2003	Программ хангамж
2	Өсвөрийн зохион бүтээгчдийн төв сургууль	Улаанбаатар	1995	1998	Бүрэн дунд боловсрол

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Ай Си Ти Групп ХХК	Технологи хариуцсан захирал	2016-2017
2	Ай Си Ти Групп ХХК	Гүйцэтгэх захирал	2014-2016
3	Айтүүлс ХХК	Гүйцэтгэх захирал	2011-2014
4	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам	Дэлхийн банкны төслийн дотооды зөвлөх	2011-2012
5	Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо	Дэлхийн банкны төслийн дотооды зөвлөх	2009-2011
6	Эрчим хүчний диспетчерийн үндэсний төв	Программист	2002-2009

**II нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Идэрмөнхийн АЛТАНТУЛГА**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1986
- Төрсөн газар: Баянхонгор аймаг



*Боловсролын талаарх мэдээлэл:*

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Удирдлагын академи	Улаанбаатар	2016	2017	Төрийн удирдлагын магистр
2	ШУТИС-КТМС	Улаанбаатар	2003	2007	Санхүүгийн удирдлагын бакалавр
3	Баянхонгор аймаг Ерөнхий боловсролын сургууль	Баянхонгор	1993	2003	Бүрэн дунд боловсрол

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Айтүүлс ХК	Гүйцэтгэх захирал	2014 оноос хойш
2	Инфо актив ХХК	Ерөнхий менежер	2012-2014
3	Ремикон ХК	Менежер	2009-2012
4	Аэро Монголиа ХХК	Нислэг үйлдвэрлэлийн менежер	2007-2009

**III нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Гантулгын ХАТАНБОЛД**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1986
- Төрсөн газар: Хөвсгөл аймаг, Тариалан сум



*Боловсролын талаарх мэдээлэл:*


№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС-КТМС	Улаанбаатар	2003	2007	Санхүүгийн удирдлагын бакалавр
2	Хөвсгөл аймаг, Тариалан сум Ерөнхий боловсролын сургууль	Хөвсгөл, Тариалан	1994	2003	Бүрэн дунд боловсрол

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Стандарт Капитал ХХК	Дэд захирал	2012 оноос хойш
2	Хера холдинг ХХК	Судалгааны ахлах ажилтан	2009-2012
3	Лайфтайм инвестмент ҮЦК ХХК	Брокер, диллер	2007-2008

**IV нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Баярмагнайн ЭРДЭНЭЖАРГАЛ**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1986
- Төрсөн газар: Сэлэнгэ аймаг, Хүдэр сум



*Боловсролын талаарх мэдээлэл:*


№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС-КТМС	Улаанбаатар	2004	2008	Бизнесийн удирдлагын бакалавр
2	Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум 3-р сургууль	Сэлэнгэ, Сүхбаатар		2004	Бүрэн дунд боловсрол

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Стандарт Инвестмент ҮЦК ХХК	Диллер	2012 оноос хойш
2	Хера холдинг ХХК	Судалгааны ажилтан	2009-2012

**V нэр дэвшигч:**

- Овог, нэр: **Нанжидын УЛААНХҮҮ**
- Хүйс: Эрэгтэй
- Төрсөн он: 1982
- Төрсөн газар: Сэлэнгэ аймаг, Орхонтуул сум



*Боловсролын талаарх мэдээлэл:*

№	Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	МУИС-ЭЗС	Улаанбаатар	2000	2005	Эдийн засгийн онолч, эдийн засагч
2	Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум 1-р сургууль	Сэлэнгэ, Сүхбаатар	1990	2000	Бүрэн дунд боловсрол

*Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Стандарт финаншл групп ХХК	Гүйцэтгэх захирал	2014 оноос хойш
2	Монет капитал ҮЦК ХХК	Хөрөнгө оруулалтын банкны хэлтсийн ахлах	2010-2014
3	Анод банк	Эрсдлийн шинжээч	2007-2009
4	Дэлхийн банк, Тогтвортой амьжиргаа төсөл	Судалгааны мэргэжилтэн	2005-2006

## ШИНЭЧИЛСЭН ДҮРМИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“АЙТҮҮЛС” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
хурлын 2018 оны 01 сарын 08 -ны өдрийн  
01/02 тоот тогтоолын 01 дүгээр хавсралт

### “АЙТҮҮЛС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

#### /ТӨСӨЛ/

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 “АЙТҮҮЛС” компани нь хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах бөгөөд /цаашид “компани” гэх/ Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмээр компанийн үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2 Компанийн албан ёсны оноосон нэр нь доор зааснаар байна.
  - 1.2.1 Монголоор: “АЙТҮҮЛС” Хувьцаат компани
  - 1.2.2 Англиар: “TOOLS” Joint Stock company
- 1.3 Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар, Баянгол, 2-р хороо, 2-р хороолол, 34, 2 тоот.
- 1.4 Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд нээлттэй ХК гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.
- 1.5 Компани өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.
- 1.6 Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байх бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлсэн байх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг зөвхөн “АЙТҮҮЛС” ХК эдэлнэ.
- 1.7 Компани нь үйл ажиллагаандаа нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ болон компанийн засаглалын шилдэг жишгийг удирдлага болгоно.
- 1.8 Компани нь хугацаагүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 1.9 Компанийг энэхүү дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөх болон өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгана.

#### ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

- 2.1 Компани нь үүсгэн байгуулагдсан үеэсээ хуулийн этгээдийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Компани нь өөрийн тусгаарласан хөрөнгөтэй байх ба бие даан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдэлнэ. Компани нь бие даасан баланс, өөрийн нэр бүхий тэмдэг, компанийн логотой байх ба Компани нь банкинд төгрөгийн, гадаад валютийн болон бусад данстай байна. Компани нь шүүх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, болон гуравдагч этгээдээр оролцох эрхтэй.
- 2.2 Компани нь өөрийн материаллаг болон мөнгөн хөрөнгөтэй байх ба тэдгээрийг ашиглах, захиран зарцуулах болон бусад эрхийг эдэлнэ.

- 2.3 Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээсэн үүргийг хариуцахгүй бөгөөд зөвхөн өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хариуцах бөгөөд Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй.
- 2.4 Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр Монгол улс болон гадаад улсад нээж болох бөгөөд Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.
- 2.5 Монгол Улсын хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлнэ.

### **ГУРАВ. КОМПАНИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ**

- 3.1 Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.
- 3.2 Компани нь хуулиар хориглоогүй дараах төрлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ.  
Үүнд:
  - 3.2.1 Программ хангамжийн үйлчилгээ,
  - 3.2.2 Мэдээллийн технологийн үйлчилгээ,
  - 3.2.3 Гадаад худалдаа.
- 3.3 Компани нь энэ дүрмийн 3.2-т заасан үндсэн үйл ажиллагаанаас гадна хууль тогтоомжоор хориглоогүй аливаа үйл ажиллагааг нэмж эрхэлж болно.
- 3.4 Монгол улсын хууль тогтоомжоор тусгай зөвшөөрөл авахаар тусгайлан заасан үйл ажиллагааг эрхлэхдээ холбогдох тусгай зөвшөөрөл авч, бүртгүүлсэнээр тухайн төрлийн үйл ажиллагааг эрхлэнэ.
- 3.5 Үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор нээлттэй зах зээл дээр үйл ажиллагаа явуулна.

### **ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ**

- 4.1 Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 100 /нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 34,452,124 /гучин дөрвөн сая дөрвөн зуун тавин хоёр мянга нэг зуун хорин дөрөв/ ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
- 4.2 Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.
- 4.3 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 3,445,212,400 /гурван тэрбум дөрвөн зуун дөчин таван сая хоёр зуун арван хоёр мянга дөрвөн зуу/ төгрөг байна.
- 4.4 Компани гүйлгээнд гаргасан өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авсан бол эдгээр хувьцааг халаасны хувьцаа гэж үзэх бөгөөд балансад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэсэгт нэрлэсэн үнээр нь хасах тэмдэгтэйгээр харуулна.
- 4.5 Компанийн нийт хөрөнгөөс өр төлбөрийг хассан дүнг өөрийн хөрөнгө гэх бөгөөд өөрийн хөрөнгийн дүн нь санхүүгийн тайлан баланс гарах бүрт өөрчлөгдөнө.

- 4.6 Жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрэмд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс бага болсон тохиолдолд ТУЗ нь ийнхүү бага болсон шалтгааныг судлан, дүгнэлт гаргаж, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах /хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар/ тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан хэлэлцүүлнэ. Хэрвээ ийнхүү бага болсон нь алдагдалтай ажилласанаас шалтгаалсан бөгөөд дахин хөрөнгөжүүлэх, хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар шийдвэрлэх боломжгүй бол компанийг татан буулгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 4.7 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хуульд зааснаас гадна дараах байдлаар өөрчилж болно. Үүнд:
  - 4.7.1 Нэмэлт хөрөнгө оруулалт хийх
  - 4.7.2 Биет болон биет бус хөрөнгийг үнэлүүлэн бүртгэх
  - 4.7.3 Компанийн өмчилж, эзэмшиж буй биет болон биет бус хөрөнгийг дахин үнэлүүлэх
- 4.8 Дүрмийн 4.7-д заасан замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хэмжээ хэвээр байна.
- 4.9 Цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаад үлдсэн ашгийн хэмжээгээр компанийн өөрийн хөрөнгө нэмэгдэх бөгөөд хувьцааны тоо өөрчлөгдөхгүй.
- 4.10 Алдагдал гарсан, үндсэн ба эргэлтийн хөрөнгийг устгасан, найдваргүй авлагыг данснаас хассан зэрэг тохиолдолд тэр хэмжээгээр компанийн хуримтлагдсан ашиг болон өөрийн хөрөнгө буурна. Хувьцааны тоо болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөхгүй.
- 4.11 Хувьцааны тоо хөрөнгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж, хорогдуулж болно. Үүнд:
  - 4.11.1 Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх
  - 4.11.2 Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөлгүйгээр хувьцааг хуваах эсхүл нэгтгэх
  - 4.11.3 Хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох.

#### **ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 5.1 Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.
- 5.2 Компанийн хувьцаа энгийн эзэмшигч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:
  - 5.2.1 Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх
  - 5.2.2 Ногдол ашиг авах
  - 5.2.3 Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх



- 5.2.4 Нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчилэн шилжүүлэх
  - 5.2.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах
    - 5.2.5.1 Нийлүүлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх
    - 5.2.5.2 Компани энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл хийх
    - 5.2.5.3 Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.
  - 5.2.6 Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон, эсхүл компанийн төрийн мэдлийн багц хувьцааг худалдсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
  - 5.2.7 Энгийн хувьцааны 5 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д нэр дэвшүүлэх хүний талаар саналаа гаргах
  - 5.2.8 Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах
  - 5.2.9 Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх
  - 5.2.10 Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувийг эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах,
  - 5.2.11 Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах
  - 5.2.12 Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84.4-т заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол уг албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах
  - 5.2.13 Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх.
- 5.3 Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй. Үүнд:

- 5.3.1 Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх
  - 5.3.2 Нийт гаргасан хувьцааны 1/3 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах
  - 5.3.3 Нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай компанид бичгээр мэдэгдэх.
- 5.4 Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

#### **ЗУРГАА. КОМПАНИЙН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ**

- 6.1 Компани энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг ТУЗ-ийн хурлын зөвшөөрлөөр гаргана.
- 6.2 Энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахаар, энгийн хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Зохицуулах байгууллагад бүртгүүлнэ.
- 6.3 Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй үнийн дүн бүхий өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. ТУЗ-ийн шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.
- 6.4 Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах, худалдах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.
- 6.5 Хувьцаа бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.
- 6.6 Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн хэлбэрээр хийж болох бөгөөд мөнгөн бус хэлбэрээр гүйцэтгэх тохиолдолд үнэлгээг тогтоохдоо ТУЗ нь мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.
- 6.7 Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу худалдан авч болно.
- 6.8 Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдаж авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна.
- 6.9 Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдаж авахаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

- 6.10 Гаргасан үнэт цаасыг худалдан авч байгаа этгээд нь компанитай тохиролцсоны үндсэн дээр төлбөрөө мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн аль ч хэлбэрээр хийж болно.
- 6.11 Компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

### **ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

- 7.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлдэх, хурлын зар мэдээг хүргэх, хурал хуралдуулах, тэмдэглэл хөтлөх, шийдвэр болон хурлын тэмдэглэлийг баталгаажуулах, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлыг холбогдох хууль, журмын дагуу зохицуулна.
- 7.2 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.
- 7.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор буюу 5 дугаар сарын 01-ны дотор ТУЗ зарлан хуралдуулна.
- 7.4 Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 50-аас дээш хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.
- 7.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдан явуулна. ТУЗ-ийн дарга хуралд оролцох боломжгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай асуудлыг шийдвэрлэсэн, ТУЗ-ийн хурлаас томилогдсон этгээд хурлыг удирдана. Хурал удирдахаар томилогдсон этгээд хуралд хүрэлцэн ирэх боломжгүй нь хурал хуралдах үед илэрхий болсон бол хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар хурал даргалагчийг сонгоно.
- 7.6 Шаардлагатай үед ТУЗ, эсхүл ТУЗ-ийн 2 буюу түүнээс дээш хараат бус гишүүн, саналын эрхийн 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч санал шаардлага гаргасан тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ТУЗ-өөс зарлан хуралдуулах, ТУЗ энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй бол тухайн этгээд өөрөө зарлан хуралдуулах эрхтэй.
- 7.7 Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Үүнд:
  - 7.7.1 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах
  - 7.7.2 Нийлүүлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах
  - 7.7.3 Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох
  - 7.7.4 Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох
  - 7.7.5 Хувьцааг хуваах буюу нэгтгэх.

- 7.8 Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 7.8.1 ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох
  - 7.8.2 Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх
  - 7.8.3 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлэх
  - 7.8.4 Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг хийх тухай шийдвэрийг ТУЗ санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхиор батлах
  - 7.8.5 Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах
  - 7.8.6 Компанийн өөрийн гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахыг зөвшөөрөх
  - 7.8.7 ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох
  - 7.8.8 ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.
- 7.9 Компанийн нэг ширхэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.
- 7.10 ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Ингэхдээ Санхүүгийн Зохицуулах хорооноос баталсан “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-ын дагуу явуулна.
- 7.11 Хувьцаа эзэмшигч өөрийгөө төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болох бөгөөд уг этгээд нь энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.
- 7.12 Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.
- 7.13 Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ.
- 7.14 Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналаа ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл бүртгэнэ. Бүртгэлийг Компанийн тухай хуулийн 67.1-д заасны дагуу томилогдсон тооллогын комиссын дарга эсхүл түүний томилсон этгээд гүйцэтгэнэ.
- 7.15 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуулийн 74.2-т заасны дагуу хөтөлж, хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж хурлын дарга гарын үсэг зурж баталгаажуулна. Хурлын тэмдэглэлийг тус бүр нэг хувийг

- гарсан шийдвэрийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад баталгаажсанаас хойш ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.
- 7.16 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Харин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.
- 7.17 Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.
- 7.18 Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.
- 7.19 Саналын хуудсыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор санал хураасан дүн, санал хураалтын тайланг тооллогын комисс гаргаж, ТУЗ-д хүргэнэ.
- 7.20 Нийт саналын эрхийн 50-аас дээш хувийг эзэмшигчид саналаа ирүүлснээр эчнээ санал хураалтыг хүчинтэйд тооцох бөгөөд саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор тухайн асуудлыг шийдвэрлэнэ.
- 7.21 ТУЗ нь энэхүү дүрмийн 7.19-д заасан тайланд үндэслэн шийдвэр гаргаж, шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд гарсан шийдвэрийн тухай мэдээллийг хурлын зар мэдээг хүргэдэг аргаар хүргэнэ.

### **НАЙМ.ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

- 8.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх журам, тэдний үйл ажиллагааны болон үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх, нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодексийн зарчимд нийцсэн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.
- 8.2 Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 1/3 доошгүй нь энэхүү дүрмийн 8.5-д заасан шалгуурыг хангасан хараат бус гишүүн байна.
- 8.3 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 1 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжилнэ.
- 8.4 ТУЗ-ийн гишүүн нь мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан компанийн эрх ашгийг тэргүүн ээлжинд эрхэмлэдэг этгээд байвал зохино.
- 8.5 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дараах шалгуурыг хангасан этгээд байна.
- 8.5.1 Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэггүй;

- 8.5.2 Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа нэгдлийн бусад оролцогч компанид эрх бүхий албан тушаал хашдаггүй;
- 8.5.3 Төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй;
- 8.5.4 Компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшдэг этгээд, эсхүл компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш байх;
- 8.6 ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо энэ дүрмийн 8.5-д заасан шалгуурыг хангасан этгээдийн нэрийг хараат бус гишүүнд нэр дэвшүүлнэ. Хараат бус гишүүнд нэрийг нь дэвшүүлж буй этгээд нь өөрөө зөвшөөрлөө бичгээр өгсөн байх бөгөөд энэ дүрмийн 8.5-д заасан шалгуурыг хангаж байгаа гэдгээ албан ёсоор баталгаажуулсан байна. Энэхүү баталгааг хуурамчаар гаргасан нь тогтоогдвол ТУЗ-ийн дарга энэ талаар хувьцаа эзэмшигч болон Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдээллэх үүрэгтэй.
- 8.7 ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлж ажиллахаас гадна дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
  - 8.7.1 Компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;
  - 8.7.2 Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн компанийн болон бизнесийн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх;
  - 8.7.3 ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд санал хураалтад оролцохгүй байх;
  - 8.7.4 Хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон компанийн засаглалын жишгийн талаар цаг тухайд нь үнэн зөв мэдээллийг бүрэн хангах;
  - 8.7.5 Өрсөлдөгч компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх.
  - 8.7.6 ТУЗ-ийн гишүүн нь үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл ТУЗ түр томилж болно.
  - 8.7.7 ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар ТУЗ-ийн даргыг сонгоно.
  - 8.7.8 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих, ТУЗ-ийн зөвшөөрснөөр тодорхой асуудлаар тушаал, шийдвэр гаргах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.
- 8.8 ТУЗ нь Компанийн тухай хууль болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 8.8.1 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратеги, энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох
  - 8.8.2 Компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөө, төсвийг батлах;

- 8.8.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, эчнээ санал хураалт явуулах эсэх шийдвэр гаргах;
- 8.8.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- 8.8.5 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах,
- 8.8.6 Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- 8.8.7 Компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
- 8.8.8 Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
- 8.8.9 Компанийн ТУЗ зөвлөлийн дэргэдэх аудитын хороог байгуулж Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй аудитын компанийг аудитын хороогоор хэлэлцүүлж, сонгох;
- 8.8.10 Ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тодорхойлох
- 8.8.11 ТУЗ-ийн үйл ажиллагааны болон компанийн сайн засаглалын зарчмуудыг хэвшүүлэхтэй холбоотой “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан бусад дотоод журмуудыг батлах,
- 8.8.12 Зарласан хувьцааны тоо, төрөлд багтаан хувьцааг гүйлгээнд гаргах шийдвэр гаргах
- 8.8.13 Өөрийн гаргасан хувьцаа болон бусад үнэт цаасыг эргүүлэн авах эсхүл худалдан авах шийдвэр гаргах
- 8.8.14 Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн дарга, захирлыг томилох
- 8.8.15 Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 8.8.16 Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 8.8.17 Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 8.8.18 Эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 8.8.19 Гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, хувь нийлүүлэн хөрөнгө оруулах, компанийн хөрөнгөөр баталгаа гаргах
- 8.8.20 Компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд хамаарахаас бусад асуудлыг шийдвэрлэх,
- 8.8.21 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.

- 8.9 ТУЗ-ийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.
- 8.10 ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байж болно.
- 8.11 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга зарлан хуралдуулах бөгөөд ТУЗ-ийн дарга нь гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн, дотоод хөндлөнгийн аудит, хөндлөнгийн аудитын байгууллагаас ирүүлсэн хурал зарлан хуралдуулах хүсэлтийг харгалзан ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.
- 8.12 ТУЗ-ийн гишүүдийн олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож буй гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 8.13 Тухайн шийдвэрлэж буй асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүд Компанийн тухай хуульд заасны дагуу санал өгөх эрхгүй бол шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 8.14 ТУЗ-ийн гишүүн нь саналын эрхээ бусад гишүүд болон гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 8.15 ТУЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, нас барсан тохиолдолд орлох гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооноос түр томилно. Түр томилогдсон гишүүн нь энэ дүрмийн 8.5-д заасан шаардлагыг хангасан байна. Хараат бус гишүүнд нэр дэвшсэн боловч сонгогдож чадаагүй гишүүдийн дотроос нөхөн сонгох асуудлыг тэргүүн ээлжинд дэвшүүлж болно.
- 8.16 ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос 2 дахин бага болсон тохиолдолд компани нь 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.
- 8.17 ТУЗ-ийн хурлын дэг болон бусад холбогдох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно.
- 8.18 ТУЗ-ийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 8.18.1 ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлж хяналт тавих, үнэн зөвийг хариуцах, гарын үсэг зурж баталгаажуулах;
  - 8.18.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
  - 8.18.3 Хувьцаа эзэмшигчдийн жил бүрийн ээлжит хурлын бэлтгэлийг энэ дүрэмд заасны дагуу хангаж байгаа эсэхэд хяналт тавих, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг гаргасан байх асуудлыг ТУЗ-ийн дарга биечлэн хариуцна;
  - 8.18.4 ТУЗ-өөс олгосон бусад эрх хэмжээ.
- 8.19 ТУЗ-ийн гишүүдэд хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон зохих хэмжээний урамшуулал олгоно.



- 8.20 Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой аудитын, цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороотой байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна.
- 8.21 8.20-д заасан хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 8.22 ТУЗ нь нарийн бичгийн дарга байх бөгөөд нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн даргын санал болгосон этгээдийг ТУЗ томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллах этгээд нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна. Нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.
- 8.23 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд түүнийг сонгох, үйл ажиллагааг нь зохицуулах хянахтай холбоотой нарийвчилсан асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно. Үүнд:
- 8.23.1 Хувьцаа эзэмшигчдын хурал, Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний хороодын хурлын бэлтгэлийг хангах, хурлын, зар, хэлэлцэх асуудалтай мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах;
- 8.23.2 Мэдээлэлийг нийтэд хүргэх арга хэмжээ авах замаар компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;
- 8.23.3 Компанийн сайн засаглалын талаар олон улсын болон бусад компанийн туршлага, төрийн болон төрийн бус байгууллагаас энэ талаар дэвшүүлж буй санал санаачлагыг судлах замаар өөрийн компанийн засаглалыг цаашид сайжруулах санал боловсруулах;
- 8.24 ТУЗ-ийн хараат бус гишүүд нь бусад гишүүдтэй адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 8.24.1 ТУЗ, гүйцэтгэх удирдлагын шийдвэр нь хууль тогтоомж, компанийн дүрэм болон холбогдох дотоод журмуудад нийцэж байгаа эсэх, компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавих, ийм зөрчилтэй шийдвэр гаргахаас сэргийлэх, гаргасан бол зөрчлийг арилгахыг шаардах, шаардлагыг эс биелүүлбэл асуудлыг ТУЗ-д тавьж хэлэлцүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахыг шаардах, хуралдуулаагүй тохиолдолд 2-оос доошгүй хараат бус гишүүн хамтран хурал зарлан хуралдуулах;
- 8.24.2 Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
- 8.24.3 Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах;
- 8.24.4 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

## ЕС. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 9.1 Компанийн гүйцэтгэх удирдлага /цаашид “гүйцэтгэх захирал” гэх/ нь энэ дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.
- 9.2 Гүйцэтгэх захирлын бүрэн эрх, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргах журам, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин урамшуулал зэргийг ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээгээр зохицуулна
- 9.3 Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлнэ.
- 9.4 ТУЗ нь компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд ТУЗ-ийг төлөөлөн дарга гарын үсэг зурна.
- 9.5 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг төлөөлөн компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:
  - 9.5.1 Компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөөний төсөл боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна;
  - 9.5.2 Хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулж батлуулан, тэдэнтэй компанийг төлөөлөн хөдөлмөрийн ба үр дүнгийн гэрээ байгуулна;
  - 9.5.3 Компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулна;
  - 9.5.4 Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох журмуудыг батална;
  - 9.5.5 Өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана;
  - 9.5.6 Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулна;
  - 9.5.7 Компанийг төлөөлөх итгэмжлэл олгоно;
  - 9.5.8 Компанийн ажиллагсдын хөдөлмөрийн сахилга бат, хөдөлмөр хамгааллын дэг журмын хэрэгжилт, технологийн горимын хэрэгжилт болон аж ахуй санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалтад хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
  - 9.5.9 Монгол улсын хууль, тогтоомж болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна.
  - 9.5.10 Компанийн түүний бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулж, ТУЗ-өөр батлуулан, ажлын байрны шаардлагыг тогтоон уг шаардлагад нийцсэн ажилтан, албан хаагчдын баг бүрдүүлэх;
  - 9.5.11 Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна;
  - 9.5.12 Хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангана;

- 9.5.13 Компанийн улирал, жилийн үйл ажиллагааны талаар ТУЗ-ийн хуралд тайлан тавьж хэлэлцүүлнэ. Энэхүү тайланд тухайн хугацаад хийсэн гэрээ, хэлцлийн дотор компанийн аль нэг эрх бүхий албан тушаалтны хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл байсан эсэх, байсан бол тухайн хэлцлийг Компанийн тухай хуулин 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай асуудлыг тусгасан байна.
- 9.5.14 Компанийн ТУЗ нь гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээнд үндэслэн албан тушаалаас нь хэдийд ч чөлөөлөх эрхтэй. Түүнийг чөлөөлсөн тохиолдолд шинээр гүйцэтгэх захирлыг сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд захирлын үүргийг түр гүйцэтгэнэ.
- 9.5.15 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад гаргаж болно. Энэхүү саналыг гаргахдаа хэлэлцүүлэх асуудлын талаарх танилцуулга, гарах шийдвэрийн төсөл зэргийг хүргүүлнэ.

#### **АРАВ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙН ХАРИУЦЛАГА**

- 10.1 ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүд, хараат болон охин компаниудын захирлуудыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 10.2 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй. Үүнд:
  - 10.2.1 Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;
  - 10.2.2 ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;
  - 10.2.3 Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаад оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;
  - 10.2.4 Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;
  - 10.2.5 Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх;
  - 10.2.6 Эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарсанаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.
- 10.3 Албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 10.2.2-т заасан үүргийг хүлээнэ.
- 10.4 Албан тушаалтан энэ дүрмийн 10.2 болон 10.3-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрээс гадна доор дурьдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас

компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна.

10.4.1 Компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;

10.4.2 Хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч, бусад оролцогчдод хуурамч мэдээлэл өгсөн;

10.4.3 Эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;

10.4.4 Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй;

10.4.5 Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгсөнөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар компанид торгуулийн арга хэмжээ оногдуулсан зэрэг компанид хохирол учруулсан эрх бүхий албан тушаалтанд Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлд зааснаар хуульд заасан хариуцлагыг оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг нөхөн төлүүлнэ.

10.5 Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба ингэж шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ ТАЙЛАН**

11.1 Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

11.2 Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

11.3 Компани нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал хариуцна. Санхүүгийн мэдээлийн үнэн зөвийг ерөнхий нягтлан бодогч гүйцэтгэх захиралтай хамтран хариуцна.

11.4 Компани нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.

11.5 Санхүүгийн тайланд дараах үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна. Үүнд:

11.5.1 Баланс

11.5.2 Орлогын, үр дүнгийн тайлан

11.5.3 Мөнгөн гүйлгээний тайлан

11.5.4 Хуримтлагдсан ашгийн тайлан

11.5.5 Нэмэлт, тайлбар, тодруулга

- 11.5.6 Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт
- 11.5.7 Эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин урамшууллын дүн, албан тушаалтан бүрийн нэрээр
- 11.5.8 Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга
- 11.5.9 Санхүүгийн тайланг гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.
- 11.6 Санхүүгийн тайланг компанийн ТУЗ-ийн зөвшөөрлөөр томилогдсон хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах бөгөөд ТУЗ санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хэлэлцүүлнэ.
- 11.7 Компани нь Компанийн тухай хуулийн 97.1-д заасан болон доор дурдсан баримт, бичгийн бүртгэлийг заавал хөтөлж, хадгалах бөгөөд бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх, холбогдох бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалсан байх нь гүйцэтгэх захирлын хариуцах асуудал болно. Үүнд:
  - 11.7.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн засаглалын, хөдөлмөрийн, цалин урамшууллын, хөдөлмөр хамгааллын гэх мэт дотоод журам, зааврын бүртгэл
  - 11.7.2 Компанийн санхүүгийн тайланд ТУЗ, аудитын хороо болон эрх бүхий бусад этгээдийн хүсэлтээр хийсэн аудитын шалтгалтын тайлангийн бүртгэл
  - 11.7.3 Компанийн бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийн бүртгэл
  - 11.7.4 ТУЗ болон гүйцэтгэх захирлын шийдвэрээр тогтоосон бусад бүртгэл
- 11.8 Компани нь энэхүү дүрмийн 11.7-д зааснаас гадна дараах баримт бичгийг хадгалж, хууль болон компанийн дүрэм, журмаар тогтоосон эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах үүрэгтэй. Үүнд:
  - 11.8.1 Компанийн тусгай зөвшөөрлүүд
  - 11.8.2 Компанийн өмчлөл болон эзэмшилд байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт
  - 11.8.3 Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт
  - 11.8.4 ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр
  - 11.8.5 Төрийн эрх бүхий хяналт зохицуулалтын байгууллагад хүргүүлсэн мэдээ, тайлан.
- 11.9 Энэ дүрмийн 11.7 болон 11.8-д заасан баримт, бичгийг 5 жил хадгалаад архивт шилжүүлнэ. Харин компанийн дүрэм, хүчин төгөлдөр гэрээ, тусгай зөвшөөрөл зэргийг байнга хадгална.
- 11.10 Компани Монгол улсын аль нэгэн болон хэд хэдэн банкинд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр

Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж байна. Компани нь гадаадын банкинд валютын данс нээх бол энэ тухайгаа Монголбанк болон Татварын албанд албан ёсоор мэдэгдэнэ.

- 11.11 Компанийн ТУЗ нь санхүүгийн тайлан, түүнд хавсаргасан нэмэлт тайлбар тодруулга, тайлангийн талаарх аудитын болон ТУЗ-ийн дүгнэлтээс гадна дараах мэдээллийг тусгасан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичнэ. Үүнд:
- 11.11.1 Компанийн бүтэц зохион байгуулалт түүнд гарсан өөрчлөлт
  - 11.11.2 Тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үйл ажиллагаа тус бүрийн талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт, үр дүн
  - 11.11.3 Компанийн өмчлөл, эзэмшилд байгаа эдийн болон эдийн бус хөрөнгө, тусгай зөвшөөрөл зэргийн талаарх мэдээлэл, эдгээрт гарсан өөрчлөлт.
- 11.12 Компанийн гүйцэтгэх захирал нь энэ дүрмийн 11.11-т заасан мэдээлэлтэй танилцах боломжоор хувьцаа эзэмшигчдийг хангана.

### **АРВАН ХОЁР. НОГДОЛ АШИГ**

- 12.1 Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.
- 12.2 Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 12.3 Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа доор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:
- 12.3.1 Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх
  - 12.3.2 Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, энэ дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх
  - 12.3.3 Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.
- 12.4 Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 12.5 Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.
- 12.6 Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээний санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болох бөгөөд уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж, ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.

- 12.7 Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.
- 12.8 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтлөнө. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкин дах дансанд шилжүүлэх бодлого баримтална.
- 12.9 Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед ногдол ашгийн хуваарилалтын тайланг гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

### **АРВАН ГУРАВ. КОМПАНИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ**

- 13.1 Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.
- 13.2 Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.
- 13.3 Дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнууддын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-тэй зөвшилцөн гүйцэтгэх захирлын баталсан “Дотоод хяналтын журам”-ын дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 13.4 Дотоод хяналтын албаны ажилтнууд нь компанийн ажилтан албан хаагчдын ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.
- 13.5 Дор дурдсан этгээдийг дотоод хяналтын албанд ажиллуулахыг хориглоно. Үүнд:
  - 13.5.1 Эрх зүйн чадамжгүй;
  - 13.5.2 Урьд нь дампуурсан компанийн удирдлагад ажиллаж байсан;
  - 13.5.3 Компанийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээд эсвэл ямар нэг шалтгаанаар тэдний нөлөөнд автах боломжтой/ найз нөхрийн болон өмнө хамт ажиллаж байсан зэргээр холбоо харилцаатай/;
  - 13.5.4 Толгой компани болон хараат буюу салбар компанид ажилладаг;
  - 13.5.5 Өмнө нь авилгын хэрэгт шийтгэгдэж байсан.
- 13.6 Дотоод хяналтын албанаас хийх шалгалт нь ээлжит болон ээлжит бус гэсэн хэлбэртэй байна. Ээлжит шалгалтын хуваарийг өмнөх жилийн 12 дугаар сард холбогдох удирдлага боловсруулан гүйцэтгэх захирлаар батлуулж ажиллана. Харин ТУЗ болон гүйцэтгэх захирлын даалгавараар, тэдний баталсан удирдамжийн дагуу тодорхой асуудлаар хийх шалгалтыг ээлжит шалгалт гэнэ.

- 13.7 Гүйцэтгэх захирал хуралдаанаар дотоод хяналтын албаны мэдээлэл, шалгалтын дүнг улирал бүр хэлэлцэн, холбогдох арга хэмжээ авч байна.
- 13.8 Монгол Улсын Аудитын тухай хуульд заасны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон гэрээ байгуулж, ажиллуулна.
- 13.9 Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.
- 13.10 Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.
- 13.11 Ээлжит бус шалгалтыг ТУЗ, түүний аудитын хорооны шийдвэр, компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн саналаар хэдийд ч хийж болно.
- 13.12 Компанийн ТУЗ-ийн аудитын хороо аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх үүрэг, хариуцлага, аудитын үйлчилгээний хөлсний хэмжээг заана. Аудитын дүгнэлтийн шинж чанараас хамааруудан аудитын хөлсний хэмжээг тогтоохыг хориглоно.
- 13.13 Аудитын ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтыг түүнийг захиалж, гэрээ байгуулж хийлгэсэн хувьцаа эзэмшигч хариуцаж төлнө. Шалгалтын явцад компанийн эрх бүхий албан тушаалтан компанид хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнө.
- 13.14 Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү-эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.
- 13.15 Эрх бүхий албан тушаалтан энэ дүрмийн 13.14-т заасан үүргээ хэрэгжүүлээгүйгээс аудиторын ажил зогссон хоногт оногдох ажлын хөлсийг буруутай албан тушаалтан хариуцан төлнө. Энэ тухай шийдвэрийг аудитын компаниас ирүүлсэн албан ёсны хүсэлтийг үндэслэн ТУЗ гаргана. Харин дээрх шалтгаанаар аудиторын ажил зогссон тухайд аудитын компани ТУЗ-ийн аудитын хорооны даргад албан ёсоор мэдэгдсэн байна.
- 13.16 Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд гаргасан дүгнэлтийнхээ талаар тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.
- 13.17 Дараах этгээдийг компанийн аудиторoor сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:
  - 13.17.1 Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол



- 13.17.2 Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хувьцаа эзэмшигч, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол
- 13.17.3 Компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол.
- 13.18 Аудитор нь дүгнэлтээ зөвхөн бичгээр гаргах бөгөөд дүгнэлтэд дараах асуудлыг заавал тусгасан байна. Үүнд:
  - 13.18.1 Компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх
  - 13.18.2 Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил илэрсэн бол зөрчлийг тохиолдол тус бүрээр тодорхойлсон
  - 13.18.3 Шалгалтын хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, эдгээр хэлцлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай дүгнэлт
  - 13.18.4 Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржээс тогтоосон бусад мэдээлэл
  - 13.18.5 ТУЗ-ийн аудитын хорооны саналаар аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бусад асуудлын талаарх мэдээлэл, дүгнэлт.

#### **АРВАН ДӨРӨВ. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ**

- 14.1 Компанийн үйл ажиллагаанд гарч болох компани түүний бизнесийн түншүүд /зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч г.м/, ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид зэргийн хооронд гарсан аливаа зөрчил маргаан, сонирхлын зөрчлийг хэлэлцэн тохирох замаар зохицуулах нь ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын анхаарлын төвд байх асуудал болно. /аливаа сонирхлын зөрчилтэй хэлцлийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр гүйцэтгэх захирал байгуулна/
- 14.2 Аливаа зөрчил, маргаан үүссэн үед компанийн эрх зүйн хэлтэс /хуулийн зөвлөх/ шалтгааныг судалж, хэрхэн шийдвэрлэж болох тухай саналаа холбогдох дээд шатны /ТУЗ-д/ удирдлагад танилцуулна.
- 14.3 Энэ дүрмийн 14.2-д заасан саналыг холбогдох удирдлага судалж үзээд зохих арга хэмжээ авах замаар зөрчлийг зохицуулах үүрэгтэй.
- 14.4 Зөрчил маргаан нь эрх бүхий албан тушаалтнуудын хооронд гарсан, эрх бүхий албан тушаалтан болон бусад оролцогч талуудын хооронд гарсан /зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч, ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид г.м/ бол зөрчил маргааныг шийдвэрлэхэд тухайн сонирхлын зөрчилтэй эрх бүхий албан тушаалтан оролцож болохгүй.

- 14.5 Компани нь Компанийн тухай хуулийн арванхоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхдээ дараах журмыг баримтална. Үүнд:
- 14.5.1 Компанитай болон охин компанитай хийж буй аливаа хэлцэлд тухайн хэлцлийг хийх талаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцох эрх бүхий аль нэг албан тушаалтан оролцож байгаа /өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, эсхүл хэлцэлд зуучлагч төлөөлөгч болж байгаа, эсхүл хэлцэлээс шууд болон шууд бусаар орлого хүртэж байгаа бол оролцож байгаа гэж үзнэ/ бол тухайн албан тушаалтан энэ тухайгаа хэлцэл хийх шийдвэр гаргах үед гүйцэтгэх захиралд болон аудитын хорооны даргад мэдэгдэнэ. Гүйцэтгэх захирал өөрөө хэлцэлд оролцогч этгээд бол ТУЗ-ийн даргад мэдэгдэнэ
- 14.5.2 Хэлцэл хийх шийдвэр гаргах болон хэлцэлтэй холбогдох үнэ тогтооход хэлцэлд оролцож буй эрх бүхий албан тушаалтан оролцож, санал өгөхгүй
- 14.5.3 Хэлцэл хийхэд оролцох этгээд гэдгээ мэдээгүй, сонихрлын зөрчилтэй хэлцлийн улмаас компанид хохирол учруулсан бол эрх бүхий алан тушаалтан уг хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө
- 14.5.4 Компанийн тухай хуулийн 92.3-т заасан тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

#### **АРВАН ТАВ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ**

- 15.1 Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
- 15.2 Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана. Үүнд:
- 15.2.1 Компанийн үйл ажиллагаа алдагдалтай /алдагдлын хэмжээг заах/ байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон
- 15.2.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийг татан буулгахаар шийдвэрлэсэн
- 15.2.3 Компанийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр.

#### **АРВАН ЗУРГАА. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

- 16.1 Энэ дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон, энэ асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхиор баталж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн албанд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.
- 16.2 Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн 16.1-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

--ooOoo--

## ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Төсөл

### АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

\_\_\_ оны \_\_ сарын \_\_ өдөр

Дугаар \_\_\_

Улаанбаатар х

*Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай.*

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Айтүүлс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд ..... ширхэг хувьцааг эзэмшдэг ..... хувьцаа эзэмшигч саналаа өгсөн нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны ..... хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад МЭДЭЭЛСҮГЭЙ.
2. Компанийн хуулийн 69.1 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны ..... хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт ТООЦСУГАЙ.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн нийт ..... асуудлаар гаргасан шийдвэрийг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн ..... хувийн саналаар зөвшөөрсөн болохыг МЭДЭГДСҮГЭЙ.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА:

\_\_\_\_\_Н.ТӨГӨЛДӨР

**АЙТГҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН  
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

\_\_\_ оны \_\_ сарын \_\_ өдөр

Дугаар \_\_\_

Улаанбаатар х

*Саналын хуудас тооллогын үр дүнгийн тухай.*

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дэх заалт, 72 дугаар зүйл, санал хураалтын хуудсын тооллогын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудад санал хураасан дүн доорх байдалтай байгааг хурлын даргад болон хуралд оролцогчдод МЭДЭЭЛСҮГЭЙ.

1. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хараат бус гишүүд

Ердийн гишүүд

Саналын хувь

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА:

\_\_\_\_\_ Н.ТӨГӨЛДӨР



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН  
ТОГТООЛ**

\_\_\_ оны \_\_ сарын \_\_ өдөр

Дугаар \_\_\_

Улаанбаатар х

***Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай***

Монгол улсын компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалтууд, 2018 оны 01 дүгээр сарын 08 –ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Айтүүлс ХК –ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олонхийн санал авсан:

Хараат бус гишүүдээр:

- 1
- 2
- 3
- 4 нарыг;

Ердийн гишүүдээр:

- 1
- 2
- 3
- 4
- 5 нарыг тус тус 2018 оны 01 дүгээр сарын 08 –ны өдрөөс эхлэн ажиллуулахаар СОНГОСУГАЙ.

**Хоёр.** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллыг 1 дүгээр хавсралтаар БАТАЛСУГАЙ.

**Гурав.** Компанийн тухай хууль болон холбогдох журмын дагуу ТУЗ –ийн дарга, ТУЗ –ийн дэргэдэх хороодыг томилон ажиллахыг ТУЗ –д үүрэг БОЛГОСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА: \_\_\_\_\_ /А.БАТТАМИР/

“Айтүүлс” ХК –ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
2018 оны 01 –р сарын 08 –ны өдрийн хурлын .... тоот  
тогтоолын 2 дүгээр хавсралт

ТУЗ –ИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

№	Үйл ажиллагаа	Жилийн зардал, ₮
1	2018 оны ТУЗ –ийн үйл ажиллагааны зардал	1,000,000₮
2	ТУЗ –ийн гишүүдийн цалин, урамшуулал	12,960,000₮
		13,960,000₮



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН  
ТОГТООЛ**

\_\_\_ оны \_\_ сарын \_\_ өдөр

Дугаар \_\_\_

Улаанбаатар хот

*Компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай*

Монгол улсын компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 2018 оны 01 дүгээр сарын 08 –ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Айтүүлс ХК –ийн дүрмийг 01 дүгээр хавсралтаар БАТАЛСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА: \_\_\_\_\_ /А.БАТТАМИР/

## САНАЛЫН ХУУДАС

### АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Айтүүлс ХК –ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 01 сарын 08 –ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар, Сүхбаатар, 8 –р хороо, Бага тойруу-49, Мэдээлэл технологийн үндэсний паркийн хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_  
 Регистрийн дугаар: \_\_\_\_\_  
 Дансны дугаар: \_\_\_\_\_  
 Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

**Нэг.** Айтүүлс ХК –ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг батламжлах. /Саналыг кумулятив аргаар тоолно/

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд:

<i>Санал: ТУЗ –ийн хараат бус гишүүнээр сонгоё</i>	<i>Нэр дэвшигчид өгөх кумулятив саналын тоо</i>
1. Зэсэмийн МЯГМАРСҮРЭН;	
2. Даваасүрэнгийн ДАВАА;	
3. Бороохойн ЭНХБОЛД;	
4. Лхагвын ТЭМҮҮЛЭН;	
5. Энхтуяагийн НАРАНМӨНХ;	
6. Пүрэв-Одсэрийн ЭНХТУЛГА;	
7. Амарсайханы ДӨЛГӨӨН;	
8. Мөнхтөрийн МӨНХБАЯСГАЛАН;	
9. Пүрэвсүрэнгийн АНХБОЛД.	

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд:

<i>Санал: ТУЗ –ийн ердийн гишүүнээр сонгоё</i>	<i>Нэр дэвшигчид өгөх кумулятив саналын тоо</i>
1. Адилбишийн БАТТАМИР;	
2. Идэрмөнхийн АЛТАНТУЛГА;	
3. Гантулгын ХАТАНБОЛД;	
4. Баярмагнайн ЭРДЭНЭЖАРГАЛ;	
5. Нанжидын УЛААНХҮҮ.	

Батлах асуудлууд: Зөвшөөрсөн Татгалзсан Түтгэлзсэн

**Хоёр.** Компанийн дүрмийг шинэчлэн батлах.

Дүрмийг шинэчлэн баталсан

2017 оны \_\_ сарын \_\_ өдөр

Гарын үсэг: \_\_\_\_\_



## САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.
  - Саналыг энгийн аргаар тоолох асуудлын хувьд саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож (√) тэмдэг тавина. Жишээ нь: зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (√), татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэн (√), түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд (√) тэмдэг тавина;
  - Засварласан, балласан, (√) –ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно;
  - ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшидэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 4 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Таны эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100\*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 500 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 5 хүртэл нэр дэвшигчид, 400 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 4 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.
2. Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол энэхүү материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер диллерийн компанидаа 2018 оны 01 сарын 05 –ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.
3. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол доорх мэдээллийг бөглөн, гарын үсэг зурж, өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг хувьцаа эзэмшиж буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ үү.

Таныг төлөөлөх хүний:

Овог, нэр: \_\_\_\_\_

Таны:

Овог, нэр: \_\_\_\_\_

Утасны дугаар: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_

АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИ  
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу-49.  
Мэдээллийн технологийн үндэсний парк 103 тоот

Утас: 99078211, 99072963, 99072783

[www.itools.mn](http://www.itools.mn)